

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРХ ЗҮЙН АЖИЛ, “ХУУЛИА ДЭЭДЭЛЬЕ”  
АЯНЫ 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 10

Пионер толгой

**Нэг. Хууль эрх зүйн ажлын талаар:**

Эрх зүйн ажлын 2024 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг гарган ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын хуулийн санд нийт **1645 ном** товхимол хууль, эрх зүйн баримт бичгүүд хадгалагдан ашиглагдаж байна. Мөн цахимаар хууль тогтоомжийн нэгдсэн файл үүсгэн албан хэрэгцээндээ ашиглаж байна. Хагас жилийн байдлаар 31 төрийн албан хаагч, иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, 4 төрийн байгууллага, 5 багийн Засаг дарга, 10 иргэнд хууль эрх зүйн лавлагаа, мэдээллийг өгч ажиллалаа. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн өөрчлөлтийг хуулийн хугацаанд хийлгэж, хянан баталгаажуулж холбогдох газарт хүргүүлсэн. Багийн Засаг дарга нарын ХАСУМ-ийг авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, томилсон.

Эхний хагас жилийн байдлаар И офисс системд байршсан захирамжийн хууль эрх зүйн үндэслэлийг тухай бүр хянан ажиллаж байна. Хууль эрх зүйн хэлтсийн сум хариуцсан мэргэжилтэнд 1 дүгээр улирлын захирамжийг явуулж хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэм хэмжээ тогтоосон актын төслийг бэлтгэсэн, сумын оршин суугчдын хурал зарлагдахгүй хүлээгдсэн.

**2.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар**

Сумын Засаг даргын Тамгын газрын залуучууд хамтран архинаас татгалзах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх уриалга гарган сумын вэб сайт, фэйсбүүк рүүппэд байршуулж сурталчилж ажиллалаа.

Сумын Засаг даргын захирамжаар Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн мэргэшсэн шинжээчээр иргэн Ц.Баатаржав ахлуулсан ажлын хэсэг хагас жилийн байдлаар 4 удаагийн хяналт шалгалтыг хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 13 дэлгүүр, 2 зоогийн газрыг хамруулан хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулан ажиллаа. Дэлгүүрээс хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг 3 удаа хураан авч устгал хийсэн.

Энэ онд нийт 42 зөрчил бүртгэгдснээс гэр бүлийн хүчирхийллээр 4, хүний биед гэмтэл учруулахгүй зодох 2, Эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 24, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 12, шүүхээр 15 хүн, торгуулийн арга хэмжээгээр 26 тус бүр 200000 төгрөгөөр торгуулсан байна.

Он гарснаар гэмт хэрэг 7 бүртгэгдэж ЭХ-ийн 11.6.1 –ээр 2 хүн /хөнгөн гэмтэл учруулах/, ЭХТА-ийн 11.1.2.1-ээр 1 хүн /хүний биед хүнд гэмтэл/, ЭХТА-ийн 27.10.2-оор хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1, ЭХТА-ийн 17.1 хулгайлах гэмт хэрэг 1, ЭХТА 13.14 –ээр худал мэдээлэл тараах 2.

Өмнөх оны мөн үетэй харьцуулах гэмт хэрэг, зөрчил өссөн үзүүлэлттэй байгаа илрүүлэлт нэмэгдэж, иргэд цагдаагийн байгууллагад хандаж мэдээлдэг болсон.

#### **Гурав. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх талаар:**

Бүх нийтийн эрх зүйн эрх боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуулийн луужин болон аймгийн хууль эрх зүйн хэлтсийн цахим хуудсанд тавигдсан мэдээллийг сумын Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн булан болон сумын цахим хуудсанд байршуулж иргэдэд сурталчилан ажиллалаа. Цахим хурлын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд мэдээллийн цаг арга хэмжээ зохион байгууллаа. Мэдээллийн цаг арга хэмжээг 14 хоног бүр төрийн байгууллагууд салбарынхаа хууль, тогтоомж, дүрэм журам, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж, 32 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 1520 гаруй иргэд, хүүхдэд сургалт зохион байгуулсан.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Гэр бүлийн тухай хууль, эмэгтэйчүүдийн эрхийн талаар хэлэлцүүлэг хийж, “Шагайн наадгайн” тэмцээн зохион байгуулж 47 ээж, эмэгтэйчүүд, 9-р ангийн сурагчдын дунд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн тухай сургалт мэдээлэл, хэлэлцүүлэг, “Алтан хонх” тэмцээнийг зохион байгуулж 40 гаруй сурагчид оролцлоо.

Шинэчлэн найруулагдсан 6 хуулиар 8 удаагийн сургалт зохион байгуулж 470 гаруй иргэд, төрийн албан хаагчид хамрагдсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 постор, 8 хуудас бүхий 16 нүүрэнд хууль тогтоомж, уриалга багтаасан гарын авлагыг бэлтгэн иргэдэд сурталчлан ажиллалаа.

Сургалтыг дараах сэдвийн хүрээнд зохион байгуулсан:

Үндсэн хууль –1

Эрүүгийн тухай хууль –3

Зөрчлийн тухай хууль -3

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль -4

Хувь хүний нууцын тухай хууль -1

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хууль -2

Зөвшөөрлийн тухай хууль-2

Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь-1

Гэр бүлийн тухай хууль тухай хууль, бусад хууль тогтоомж, дүрэм журмаар 15 нийт 32 удаагийн танхимын сургалт зохион байгуулагдсан.

Үндсэн хуулийн өдөр, анхдугаар үндсэн хуулийн 100 жилийн ойг угтан аймгийн ГХУСАЗЗ, аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсээс санаачлан бүтээсэн 62 шторкоос 15-ыг сумын фэйсбүүк хуудсанд, вэб сайтад байршуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Мөн Засаг даргын Тамгын газраас 21 төрлийн гарын авлагыг 150 гаруй иргэд малчдад, 3 төрлийн гарын авлагыг 90 гаруй малчид иргэдэд тарааж нийт 240 иргэдэд авлага хүргэсэн.

#### **Дөрөв. Байгууллагуудын архив албан хэргийн ажлыг сайжруулах талаар:**


Засаг даргын Тамгын газрын 2021 оны 141 байнга хадгалах хадгаламжийн нэгж, Ерөнхий боловсролын сургууль 2021 оны 65 хадгаламжийн нэгж, Эрүүл мэндийн төв 2021 оны 55 хадгаламжийн нэгж, Цэцэрлэг 42 хадгаламжийн нэгж, Соёлын төв 24 хадгаламжийн нэгж, нийт 5 байгууллага 327 байнга хадгалах хадгаламжийн нэгжийг тус тус байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн, эрэмбэлэн скайнардаж мастер хувь үүсгэн үүнээсээ photoshop программыг ашиглан цэвэрлэж ашиглалтын хувь үүсгэн Төрийн архивын [www.edocument.gov.mn](http://www.edocument.gov.mn) цахим программд өгөдлийн дагуу цахимаар ашиглалтын болон нөөц хувь үүсгэн байгууллагын нэрийн өөрчлөлт, газарзүйн байрлал, байгууллагын нэр, хүний нэр, зүйлийн заагч зэргээр нэг бүрчлэн шивж оруулан 3 хувь дансны хамт Төрийн архивын тасагт хүлээлгэн өгсөн. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал архивын баримтаа хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хийгдэж байна.

Байгууллагуудын ERP програмын ашиглалтыг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудаар архив бичиг хэргийн эрхлэгч, хууль эрхзүйн мэргэжилтэн хамтран заавар зөвлөгөө өгч архив бичиг хэргийн ажилтнууд байгууллагын дарга нартай хамтран ажиллалаа. Төрийн байгууллагууд албан бичиг, өргөдөл гомдол, хүний нөөц, олон нийт гэсэн цэсүүдийг бүрэн ашиглаж байна.

ERP” системийн албан бичиг, хүний нөөц цэсийг үйл ажиллагаандаа ашиглаж

байгаа ба бусад модулийг бүрэн ашиглаж хэвшээгүй байна. ЗДТГ-ын 28 албан хаагч, ИТХ-ын 3, ЕБС-ийн 7, ЭМТ-ийн 4, Цэцэрлэгийн 3, Соёлын төвийн 3 албан хаагч нийт 48 албан хаагч ERP системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ХЯНАСАН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Р.ТАНТУЛГА

ТАЙЛАН БИЧСЭН  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН  Л.АЧМАА

